



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/268

Мандалговь

Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн
сургалтын зардалд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а" Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, Засаг даргын зөвлөлийн хурлын 2021 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 11 дүгээр тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дундговь аймгийн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг чадавхижуулах сургалт, дадлагын зардалд 1,599,000 /нэг сая таван зуун ерэн есөн мянган/ төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 1,599,000 /нэг сая таван зуун ерэн есөн мянган/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор)-т зөвшөөрсүгэй.

3. Зардлын төрлийг хавсралтаар баталсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210913